

Байгаль орчин, аялал жуулчлалын  
сайдын 2017 оны 04-р сарын 27-  
ны өдрийн А/1107 дугаар тушаалын  
хавсралт



**АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>Зорилго</b>		<b>Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх</b>				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгальд ээлтэй инженерийн дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрийг багасган дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг хязгаарлаж, агаар, орчны бохирдлыг 80 хувиар бууруулна.				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
<b>Зорилт 1. Хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулан хот, суурин газрын агаар, орчны чанарыг сайжруулах</b>						
<b>Үйл ажиллагааны чиглэл 1. Хүн амын суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, бүс нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар нийслэлийн хүн амын төвлөрлийг зогсоох</b>						
1.1.1	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл боловсруулж УИХ-аар батлуулсан байна. Түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулсан байна.	БХБЯ	Холбогдох яам, агентлаг, АНЗД	2017-2019
			15 аймгийн хэмжээнд ерөнхий төслийг боловсруулсан байна.	БХБЯ	Холбогдох яам, агентлаг, АНЗД	2018-2021

1.1.2	Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлт”-ийн бодлого хэрэгжүүлэх	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /ААНОАТ/ хуулийн хэрэгжилт	ААНОАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ААНБ-ын орлогын албан татварыг 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлөлт үзүүлсэн байна.	СЯ		2017-2025
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.</b> Нийслэлд шилжин ирэх хөдөлгөөнийг хязгаарлаж, нийслэлийн гэр хорооллын тэлэлтийг зогсоож, яндангийн тоог нэмэгдүүлэхгүй байх						
1.2.1	Улаанбаатар хот руу шилжин ирэх хөдөлгөөнийг хязгаарлаж, гэр хорооллын тэлэлтийг зогсоох	Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хязгаарыг тогтоох, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэр	Улаанбаатар хотын гэр хорооллын тэлэлтийг зогсоох шийдвэрийг хэрэгжүүлэх	НЗДТГ		2017-2018
<b>Үйл ажиллагааны чиглэл 3.</b> Нүүлгэн шилжүүлэлт, дахин төлөвлөлтийн эрхзүйн орчныг бүрдүүлж, ачаа тээврийн төмөр зам, хурдны автозамын төсөл хэрэгжүүлэх						
1.3.1	Нүүлгэн шилжүүлэх, дахин төлөвлөх эрхзүйн орчныг бүрдүүлэх	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох шийдвэр	1. Нийслэлийн эрхзүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.	НЗДТГ	БХБЯ	2017-2018
			2. Ачаа тээврийн төмөр зам байгуулах, арьс шир, ноос ноолуур болон бохирдол ихтэй бусад үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулсан байна.	НЗДТГ	БСШУСЯ, ЗТХЯ, ХХААХҮЯ, БХБЯ	2017-2018
			Хот, суурин газрыг дахин төлөвлөх тухай хууль, түүнийг дагалдан гарах дүрэм, журам, заавар, аргачлал	Хууль, дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулан батлуулсан байна.	БХБЯ	ХЗДХЯ, БХТ, ГЗБГЗЗГ, АНЗДТГ
1.3.2	Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох “ухаалаг” жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлэх	Жишиг “ухаалаг” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	Жишиг “ухаалаг” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	БХБЯ	ЗТХЯ, холбогдох яамд, НЗДТГ, Төв аймгийн ЗДТГ	2018-2025

1.3.3	Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-Улаанбаатар чиглэлийн хурдны автозамыг барих	Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-Улаанбаатар чиглэлийн 32 км хурдны автозам	32 км хурдны автозамыг барьж ашиглалтанд оруулсан байна.	ЗТХЯ		2017-2019
1.3.4	“Богдхан” төмөр замыг барьж, ашиглалтанд оруулах	“Богдхан” төмөр зам	“Богдхан” төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилга угсралтын ажлыг зохион байгуулсан байна.	ЗТХЯ	УБТЗ ХНН, Төв аймгийн ЗДТГ	2017-2022
<b>Үйл ажиллагааны чиглэл 4.</b> Төрийн байгууллага, их, дээд, сургуулийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, зохион байгуулах						
1.4.1	Төрийн байгууллага, их дээд, сургуулийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, зохион байгуулах	Нүүлгэн шилжүүлэх холбогдох шийдвэр	Төрийн зарим байгууллага, их дээд сургуулийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулж, хэрэгжүүлсэн байна.	ЗГХЭГ, БСШУСЯ	БХБЯ, холбогдох яамд	2017-2020
<b>Үйл ажиллагааны чиглэл 5.</b> Хөрөнгө оруулалтыг орон нутаг руу чиглүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, хөдөөгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх						
1.5.1	Сонгосон томоохон сууринд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк /ХААҮТП/ барих загвар төслүүдийг хэрэгжүүлэх	ХАА-н боловсруулах үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх байршлын судалгаа	ХАА-н боловсруулах үйлдвэрлэлийн кластерын хөгжил, байршлын судалгаа хийгдсэн байна.	ХХААХҮЯ		2017
		Сонгосон 10-аас доошгүй томоохон хот суурин дахь хөдөө аж ахуйн ҮААҮТП	Сонгосон 10-аас доошгүй томоохон сууринд ХААҮТП байгуулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлсэн байна.	ХХААХҮЯ	АНЗД	2018-2021
1.5.2	Хөдөө орон нутагт шилжин очсон иргэдэд малжуулах, зөгийжүүлэх зэргээр өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг бүрдүүлэх	Хөдөөд бий болгосон малжуулах, зөгийжүүлэх төсөл, өрхийн үйлдвэрлэл	Хотоос хөдөө орон нутагт шилжин очсон иргэдэд малжуулах, зөгийжүүлэх, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зэрэг боломжийг бүрдүүлсэн байна.	ХХААХҮЯ, ХНХЯ	АНЗД	2017-2021
1.5.3	Хөдөө орон нутагт шилжин очсон иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох эрхзүйн зохицуулалтыг бий болгож хэрэгжүүлэх	Нийслэлээс нүүж хөдөө орон нутагт суурьшихыг дэмжих урамшууллын хөшүүрэг, татварын хөнгөлөлт	Хөдөө орон нутагт суурьшихыг урамшуулах хөшүүрэг, татварын хөнгөлөлт бий болсон байна.	СЯ, АНЗД	ХНХЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ	2017-2021

**Үйл ажиллагааны чиглэл 6.** Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, дэд станцыг өргөтгөн хүчин чадлыг нь нэмэгдүүлж, гэр хорооллын айл өрх 2.5-4кВт хүчин чадалтай цахилгаан халаагуур техникийн боломжийг бүрдүүлэх

1.6.1	Улаанбаатар хотын гэр хорооллын 110 000 айл өрхийг 2.5-4кВт хүчин чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх, барилга угсралтын ажлын зураг төсөл хийх	Улаанбаатар хотын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, барилга угсралтын ажлын зураг төсөл	Улаанбаатар хотын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, барилга угсралтын ажлын зураг төсөл хийгдсэн байна.	ЭХЯ	НЗДТГ	2017-2018
1.6.2	Улаанбаатар хотын гэр хорооллын 110 000 айл өрхийг 2,5 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх	Цахилгаан дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр дэд станц	110 000 айл өрхийг 2,5 кВт цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.	ЭХЯ	НЗДТГ	2017-2019
		Цахилгаан түгээх сүлжээний хүчин чадлын нэмэгдэлт		ЭХЯ	НЗДТГ	2017-2018
1.6.3	Улаанбаатар хотын гэр хорооллын 20 000 айл өрхийг 4,0 кВт цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх	6-10кВ-ын хуваарилах байгууламж, цахилгаан дамжуулах шугам, трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх түгээх сүлжээний өргөтгөл	20 000 айл өрхийг 4,0 кВт цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.	ЭХЯ	НЗДТГ	2017-2018
1.6.4	Улаанбаатар хотын гэр хорооллын 68 000 хэрэглэгчдийг 4,0 кВт чадалтай цахилгаан халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх	6-10кВ-ын хуваарилах байгууламж, цахилгаан дамжуулах шугам, трансформаторын хүчин чадлыг нэмэгдүүлэх түгээх сүлжээний өргөтгөл	68 000 айл өрхийг 4,0 кВт цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.	ЭХЯ	НЗДТГ	2018-2021
1.6.5	Гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг цахилгаан эрчим хүчинд холбох	Шинээр цахилгаан шугам сүлжээнд холбогдсон 5800 айл өрх	Гэр хорооллын 5800 айл өрхийг цахилгаан эрчим хүчинд холбож, 4,0 кВт цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.	ЭХЯ	НЗДТГ	2017

**Үйл ажиллагааны чиглэл 7.** “Хямд өртөгтэй орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гэр хороололд амины орон сууцыг барихад чиглэсэн дэд бүтцийг байгуулж, орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх, залуучууд, бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах

1.7.1	“Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	20,000 айлын түрээсийн орон сууцны сан	20,000 айл түрээсийн орон сууцаар хангагдах боломж бүрдэнэ.	БХБЯ	ТОСК	2017-2021
1.7.2	Гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэн бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах	Бага, дунд орлоготой иргэдэд олгосон урт хугацаатай, бага хүүтэй орон сууцны зээл	Гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэн бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах ажлыг эрчимжүүлсэн байна.	БХБЯ, МБ	СЯ	2017-2025
			Орон сууцны зах зээл дээр бэлэн байгаа орон сууцнуудыг эргэлтэнд оруулах механизмыг судлан, гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах боломжийг бүрдүүлсэн байна.	СЯ, БХБЯ	НЗДТГ, НОСК, ТОСК	2017-2018
1.7.3	"Ногоон хувийн орон сууц" загвар төслийг үе шаттай эхлүүлэх	Олон улсын стандартад нийцсэн ногоон хувийн орон сууцны хороолол	Загвар төслийг хэрэгжүүлсэн байна.	БХБЯ, НЗДТГ	ЭХЯ	2018-2020
1.7.4	Шинээр баригдах орон сууцны барилгын зураг төсөлд хийн хангамж болон саарал усны инженерийн шугам сүлжээг тусгаж, хэрэгжүүлэх	Хийн хангамжийн шугам бүхий барилга	Зураг төслийн дагуу хийн хангамжийн шугам сүлжээ бүхий барилгууд баригдаж, хэрэглэгчийг хийгээр хангах техникийн боломж бүрдсэн байна.	БХБЯ, ЭХЯ	АНЗД, УУХҮЯ	2018-2025
		Саарал усны шугам бүхий барилга	Зураг төслийн дагуу саарал усны шугам сүлжээ бүхий барилгууд баригдаж ахуйн хэрэглээний саарал усыг эргүүлэн ашиглах техникийн боломж бүрдсэн байна.	БХБЯ	БОАЖЯ, АНЗД	2018-2025
<b>Үйл ажиллагааны чиглэл 8.</b> Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн инженерийн хангамжид холбох, дэд төвүүдийг байгуулах, сэргээгдэх эрчим хүчний технологи нэвтрүүлэх						
1.8.1	Улаанбаатар хотын Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламжийг үе шаттайгаар барьж байгуулах	Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламж	Улаанбаатар хотын Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламжийг үе шаттайгаар барьж байгуулсан байна.	НЗДТГ, БХБЯ		2017-2021

1.8.2	Улаанбаатар хотын агаарын бохирдол ихтэй гэр хорооллыг сонгон “Бичил дэд төв”-үүдийг байгуулах	Хэрэглэгчийг инженерийн дэд бүтцээр хангах Бичил дэд төвүүд	Гэр хорооллын нөхцөл сайжирч, 200-300 айл өрхийг хэсэгчилсэн инженерийн дэд бүтцээр хангах Бичил дэд төвүүдийг байгуулсан байна.	БХБЯ	НЗДТГ, ЭХЯ	2017-2025
1.8.3	Цэргийн хүрээ, хотхоныг байгальд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлсэн жишиг суурин болгон хөгжүүлэх	Жишиг ногоон суурин	Байгальд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлсэн жишиг суурин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна.	БХЯ	БХБЯ, АНЗДТГ	2017-2025
1.8.4	Нар, салхи, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	10-50 МВт -ийн сэргээгдэх эрчим хүчний төслүүд	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, ашиглалт нэмэгдсэн байна.	ЭХЯ, ЭХЗХ	БОАЖЯ, НЗДТГ, ХХ	2017-2020
1.8.5	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг дэмжиж урамшуулах	Цэвэр эрчим хүч буюу сэргээгдэх эрчим хүчний жижиг төслүүд, ашиглалт	Сэргээгдэх эрчим хүчийг дэмжиж иргэн, ААНБ-ын илүүдэл эрчим хүчийг төр худалдан авах тогтолцоог бий болгосон байна.	ЭХЯ, ЭХЗХ	БОАЖЯ, НЗДТГ, ХХ	2019-2025
1.8.6	Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй Улаанбаатар хотын захын хэрэглэгчдийг бие даасан хийгээр ажилладаг дулааны эх үүсвэр ашиглан дулаанаар хангах	Хийгээр ажиллах хэсэгчилсэн дулаан хангамжийн систем	Түүхий нүүрсний хэрэглээг орлуулж хийн түлшээр дулааны хангамжийг шийдсэн хэрэглэгчийн тоо нэмэгдсэн байна.	ЭХЯ, ЭХЗХ		2018-2023
<b>Үйл ажиллагааны чиглэл 9.</b> Улаанбаатар хотод ажиллаж байгаа халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчийг төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжид үе шаттайгаар холбох						
1.9.1	Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа 228 халаалтын зуухыг үе шаттайгаар буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох	228 уурын зуухыг буулгаж, барилгуудыг төвлөрсөн дулаан хангамжид холбох зураг төсөв	228 ш халаалтын зуухыг буулгаж, 445 барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох зураг төсөв хийгдсэн байна.	ЭХЯ	НЗДТГ	2017
		1-р үе шат: 123 ш халаалтын зуух буулгах	Халаалтын 123 ш зуухыг буулгаж, 263 барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбосон байна.	ЭХЯ	НЗДТГ	2017-2018

		1-р үе шат: 105 ш халаалтын зуух буулгах	Халаалтын 105 ш зуухыг буулгаж, 182 барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбосон байна.	ЭХЯ	НЗДТГ	2019-2020
<b>Үйл ажиллагааны чиглэл 10.</b> Хот, суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох						
1.10.1	Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	1230 өрхийн жишиг сайжруулсан ариун цэврийн байгууламж	Төслийн нэгжийг байгуулж, төсөл хэрэгжиж эхэлсэн байна. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийг туршиж, 1230-аас доошгүй өрхөд суурилуулсан байна.	БОАЖЯ	БХБЯ, АНЗД	2017-2018
		1440 өрхийн сайжруулсан ариун цэврийн байгууламж	Сайжруулсан ариун цэврийн байгууламжийг туршиж, 1440-аас доошгүй өрхөд суурилуулсан байна.	БОАЖЯ	БХБЯ, АНЗД	2019-2021
1.10.2	Инженерийн дэд бүтцийн хангамжид холбогдох боломжгүй айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний байгууламжид MNS 5924:2015 стандартыг мөрдүүлэх	Шинэ дэвшилтэт технологи ашиглан MNS 5924:2015 стандарт мөрдүүлэхэд үзүүлэх дэмжлэг	1000-аас доошгүй айл өрхөд нүхэн жорлон, угаадасны нүхний байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэх ажилд дэмжлэг үзүүлсэн байна.	БХБЯ	АНЗДТГ	2017-2020
		Стандартад нийцсэн сайжруулсан нүхэн жорлон, угаадасны нүхний байгууламж	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлж, ТХЗ-ыг хангах нөхцөл бүрдэнэ.	АНЗДТГ, МХЕГ	БХБЯ	2017-2025
1.10.3	Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үйлчилгээний байгууллага/жуулчны бааз, зочид буудал, дэлгүүр болон бусад/-ын ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар боловсронгуй болгох	Сургууль, цэцэрлэг, үйлчилгээний байгууллагын стандартын шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламж	Нийслэлийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, шатахуун түгээх станц, дэлгүүр болон бусад үйлчилгээний байгууллагын нийтийн ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлсэн байна.	НЗДТГ, МХЕГ	БХБЯ, ХХ	2017-2025
			Хөдөө орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, шатахуун түгээх станц, дэлгүүр болон бусад үйлчилгээний байгууллагын нийтийн ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар боловсронгуй болгож, стандартын шаардлагыг хангуулсан байна.	АНЗДТГ	БХБЯ, МХЕГ, ХХ	2017-2025

<b>Үйл ажиллагааны чиглэл 11.</b> Арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, авто техникийн болон барилгын материалын захыг нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлж, инновацид тулгуурласан ногоон технологи бүхий үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх						
1.11.1	Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрийн парк байгуулж, үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, загвар үйлдвэр байгуулах	Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт	Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрлэгдэж, бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна.	НЗДТГ, ХХААХҮЯ	СЯ, БХБЯ, БОАЖЯ	2017-2023
1.11.2	Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрийн парсад зориулан хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийг байгуулах	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ	ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.	НЗДТГ	СЯ, ХААХҮЯ, БХБЯ, БОАЖЯ	2018
		Арьс, ширний үйлдвэрийн паркийн орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламж	Орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламж ашиглалтанд орсон байна.	НЗДТГ	СЯ, ХХААХҮЯ, БХБЯ, БОАЖЯ	2018-2021
1.11.3	Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа автотехникийн захыг нүүлгэн шилжүүлж нэгдсэн цогцолборт төвлөрүүлэх	Авто худалдааны нэгдсэн цогцолбор	Авто техникийн захуудыг нүүлгэн шилжүүлж, Авто худалдааны нэгдсэн цогцолборыг үйл ажиллагаанд оруулсан байна.	НЗДТГ	АТҮТ	2017-2019
1.11.4	Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа барилгын материалын захуудыг нүүлгэн шилжүүлэх	Барилгын материалын бөөний худалдааны төвийн ТЭЗҮ	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж, төвлөрсөн худалдаа үйлчилгээг бий болгосон байна.	НЗДТГ	БХБЯ, ХААХҮЯ	2017-2018
		Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк				2017-2019
<b>Үйл ажиллагааны чиглэл 12.</b> Хот, суурин газрын орчимд элс, хайрганы олборлолт, үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хязгаарлаж, газрыг нөхөн сэргээх						
1.12.1	Хот, суурин газрын суурьшлын бүс, голын хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг хориглох	Хот, суурин газрын суурьшлын бүс, голын хамгаалалтын бүсэд цуцалсан түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	Хот, суурин газрын суурьшлын бүс, голын хамгаалалтын бүсэд олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалж, шинээр хайгуулын зөвшөөрөл олгохгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	АНЗДТГ	БОАЖЯ, УУХҮЯ	2017-2020



		Хот, суурин газрын орчмын түгээмэл тархацтай ордын нөхөн сэргээсэн талбай	Ашиглагдсан ордыг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулсан байна.	АНЗДТГ	ХХ	2017-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 13.</b> Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хот, суурин газрын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх						
1.13.1	Орон сууц, гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд зураг төслийн дагуу бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах	Шинээр байгуулсан бичил цэцэрлэгт хүрээлэн	60 гаруй бичил цэцэрлэгт хүрээлэнг байгуулсан байна. Тарьсан мод сөөгний амьдралт 70-80 хувьтай болсон байна.	НЗДТГ	АЗДТГ	2017-2021
1.13.2	Хот суурин газрын ногоон бүсийн барилгын стандарт, нормыг боловсронгуй болгох	Стандарт, шинэчилсэн норм дүрэм	3 давхраас илүүгүй өндөртэй байх шаардлага тавигдаж, байгалийн өнгө төрхтэй хосолсон төлөвлөлт хийгдэх нөхцөл бүрдэнэ.	БХБЯ, СХЗГ	БОАЖЯ	2017-2018
1.13.3	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах орон сууцны хорооллын талбайн 20 хувиас доошгүй хэсгийг ногоон байгууламжтай болгох	Ногоон байгууламжийн төлөвлөлт, шинээр бий болгосон ногоон байгууламж	Орон сууцны хорооллын 20 хувиас доошгүй хэсгийг ногоон байгууламжтай байх шаардлагыг зураг төсөвт тусгах, барилгын ажилтай хамт эхлүүлж улсын комисс хүлээн авах эрхзүйн тогтолцоо бүрдэж хэрэгжсэн байна.	НЗДТГ	БХБЯ	2017-2025
				АЗДТГ	БХБЯ	2017-2025
1.13.4	Ургамлын бүрхэвчгүй сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлэх	600 мянган кв.м зүлэгжүүлэлт хийсэн талбай	Жилд 150 мянган кв.м талбайг зүлэгжүүлсэн байна.	НЗДТГ		2017-2021
1.13.5	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мод тарих санал санаачилгыг дэмжих	Гэр бүл, хамт олны нэрэмжит төгөл	Ногоон бүсэд мод тарих нэрэмжит цэцэрлэгүүдийг бий болгож, гэр бүл, хамт олны нэрэмжит төгөл тарих нөхцлийг бүрдүүлсэн байна.	НЗДТГ	БОАЖЯ, АЗДТГ	2017-2025
<b>Үйл ажиллагааны чиглэл 14.</b> Туул гол, түүний цутгал Сэлбэ, Улиастай, Баянгол, Зүүн салаа, Баруун салаа, Толгойт зэрэг голуудад хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлж, үерийн далан болон хамгаалалтын бүсэд буусан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нүүлгэх бэлтгэл ажлыг хангаж, үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх						

1.14.1	Усны сан бүхий газрын газар олголтыг цэгцэлж хууль тогтоомжид нийцүүлэх, Туул гол, түүний цутгал Сэлбэ, Улиастай, Баянгол, Зүүн, Баруун салаа, Толгойт зэрэг голуудад хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх	Хяналт шалгалт, газар олголтыг цэгцэлсэн шийдвэр	Усны нөөцийг хомсдох, бохирдохоос сэргийлэх, үер усны аюулаас хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах нөхцөл бүрдэнэ.	НЗДТГ	МХЕГ, Туул голын СГЗ	2017-2025
1.14.2	Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, голуудын хамгаалалтын бүс болон үерийн далан дотор буусан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нүүлгэх бэлтгэл ажлыг хангаж, нүүлгэх ажлыг шат дараатай гүйцэтгэх	Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, голуудын хамгаалалтын бүс, үерийн далангийн бүсээс нүүлгэн шилжүүлсэн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага	Голын хөндийд бүрэлдэх утааны нягтшил багасаж, хүний амь нас үер усны гамшгаас хамгаалагдсан байна.	НЗДТГ	МХЕГ, Туул голын СГЗ	2017-2021
<b>Зорилт 2. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах</b>						
<b>Үйл ажиллагааны чиглэл 1.</b> Хот, суурин газрын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг шинэчлэн тогтоож, халаалтын зориулалтаар шатааж хэрэглэхийг хориглох зүйлсийн жагсаалтыг гарган мөрдүүлэх						
2.1.1	Агаарын тухай хуулийн дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсийг тухай бүр шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг хангах	Бүсийг шинэчлэн тогтоосон шийдвэр, бүсэд мөрдөх журам	БОАЖС, НЗД-ын хамтран тогтоосон агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг хангуулсан байна.	НЗДТГ, МХЕГ	БОАЖЯ, ЭХЯ, АНЗД, ТББ	2017-2025
2.1.2	Гэр хорооллын айл өрх, амины орон сууцны хороолол, үйлчилгээний барилга, ТҮЦ, ШТС, машин угаалгын газар, авто засвар, дугуй засвар, 2-догч түүхий эд хүлээн авах цэг зэрэгт агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийг мөрдүүлэх	Дэглэмийг мөрдүүлсэн амины орон сууцны хороолол, үйлчилгээний барилга, ТҮЦ, машин угаалгын газар, авто засвар, дугуй засвар, 2-догч түүхий эд хүлээн авах цэг	Айл өрх, амины орон сууц, үйлчилгээний барилга, ТҮЦ, машин угаалгын газар, авто засвар, дугуй засвар, 2-догч түүхий эд хүлээн авах цэг зэрэгт хяналт шалгалт явуулж, бүсийн дэглэмийг мөрдүүлсэн байна.	НЗДТГ, МХЕГ	Холбогдох яамд	2017-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.</b> Дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг үе шаттайгаар хориглох						
2.2.1	Түлш, гэрийн зуухны холбогдох стандартыг айл өрхөд мөрдүүлэх	Түлш, зуухны стандартууд	Холбогдох стандартуудыг боловсруулж, мөрдүүлсэн байна.	ЭХЯ, АНЗДТГ	МХЕГ	2017-2025

2.2.2	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрс хэрэглэхийг үе шаттайгаар хориглох	Түүхий нүүрсийг халсан агаарын чанарыг сайжруулах 1, 2, 3, 4-р бүс	2018 он гэхэд Агаарын чанарыг сайжруулах 4-р бүсэд, 2020 гэхэд 3-р бүс, 2025 он 1, 2-р бүсэд түүхий нүүрсний хэрэглээг бүрэн халсан байна.	НЗДТГ, ЭХЯ	БОАЖЯ	2017- 2025
<b>Үйл ажиллагааны чиглэл 3.</b> Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг дэмжин түүхий нүүрсний хэрэглээг орлуулах						
2.3.1	Нийслэлийн гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлш үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх	Боловсруулсан түлшний үйлдвэрүүдэд үзүүлэх дэмжлэг	Жилд 100 мян-аас доошгүй тонн боловсруулсан түлш үйлдвэрлэдэг болсон байна.	ЭХЯ, ААНБ	НЗДТГ, ЗТХЯ	2017- 2018
		Таван толгойн нүүрсний уурхайгаас Улаанбаатар хот руу 80000 тн баяжуулсан нүүрсийг тээвэрлэх тээврийн сүлжээ	2017 онд 23 000, 2018-2021 онуудад жилд 43 000 айл өрхийг сайжруулсан түлшээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	ЭХЯ, ААНБ	НЗДТГ, ЗТХЯ	2017-2025
		Тээвэрлэлтийн сүлжээ, Чойр өртөөн дээр байгуулсан автомашинаас төмөр замд ачиж буулгах станц	Тавантолгойгоос Улаанбаатар хүртэл баяжуулсан нүүрсний тээвэрлэлтийн асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулсан байна.	ЗТХЯ	ЭХЯ, НЗДТГ, УУХҮЯ	2017-2025
		Цемент бетон хучилттай 500 км авто зам	Цемент бетон хучилттай 500 км авто зам барьж ашиглалтанд оруулсан байна.	ЗТХЯ		2018-2021
2.3.2	Сайжруулсан түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох	Боловсруулсан түлшний нөөцлөх цэг, борлуулалтын сүлжээ	Түгээлт, борлуулалтын цэгүүдийг байгуулсан байна.	НЗДТГ		2017-2025
2.3.3	Био, шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх	Ойн цэвэрлэгээнээс гарсан модыг боловсруулж, шахмал түлшний түүхий эд бэлтгэх дэвшилтэт техник, технологи	Жилд шахмал түлшний 300 мянган шоомтрээс доошгүй түүхий эдийг ойн цэвэрлэгээгээр бэлтгэсэн байна.	БОАЖЯ, АЗДТГ, ААНБ	ХХААХҮЯ	2018-2023
		Био, шахмал түлшний үйлдвэр	Био, шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, хот суурин газарт нийлүүлсэн байна.	ХХААХҮЯ, ЭХЯ	АНЗДТГ	2017-2025

<b>Үйл ажиллагааны чиглэл 4.</b> Гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхийн шөнө хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50-100 хувь хөнгөлөх						
2.4.1	Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчийг хөнгөлөх	Шөнийн цахилгаан эрчим хүчийг хөнгөлөлт	Түүхий нүүрсний шаталтаас үүдэлтэй агаарын бохирдол буурсан байна.	ЭХЯ, ЭХЗХ	НЗДТГ	2017-2025
2.4.2	Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан зуух, түлш болон цахилгаан халаагуураар хангах дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамруулж, зуух олгосон зорилтот бүлгийн айл өрх	1000-аас доошгүй зорилтот бүлгийн өрхийг дэмжлэгт хамруулсан байна.	БОАЖЯ, НЗДТГ	ЭХЯ, ХНХЯ	2017-2020
		Зорилтот бүлгийн айл өрхөд нийлүүлсэн боловсруулсан түлш	Зорилтот бүлгийн 13 000 айл өрхийг боловсруулсан түлшээр хангасан байна.	ХНХЯ	НЗДТГ, ХХ	2017-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 5.</b> Байгальд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи бүхий барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн зохицуулалт бий болгож хэрэгжүүлэх						
2.5.1	Худалдан авах ажиллагааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, барилгын материалын дотоодын үйлдвэрлэгчийг бодлогоор дэмжих	Холбогдох хуулийн нэмэлт өөрчлөлт	Байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, дэвшилтэт технологи бүхий барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих эрхзүйн зохицуулалт бий болгож хэрэгжүүлсэн байна.	СЯ, БХБЯ	ХХ	2017-2025
2.5.2	Барилгын дулаан алдагдлыг бууруулахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий барилгын материалын дотоодын үйлдвэрүүдийг дэмжих	Барилгын ногоон материалын үйлдвэрлэлийн судалгаа, мэдээллийн сан	Ногоон барилгын материалын мэдээллийн цахим сан бий болсон байна.	БХБЯ	БОАЖЯ	2017-2018
		Байгаль орчинд ээлтэй дулаан тусгаарлах материал, шил, ган, цементийн үйлдвэрүүд	Байгаль орчинд ээлтэй дулаан тусгаарлах материал, шил, ган, цементийн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлсэн байна.	БХБЯ	ХХ	2018-2024
<b>Үйл ажиллагааны чиглэл 6.</b> Гэр, байшингийн дулаалгыг сайжруулж, дулааны алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх						
2.6.1	“Барилгын салбарт үндэсний онцлогт тохирсон хүлэмжийн хийг бууруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх	Барилгын дулаан алдагдал, хүлэмжийн хийн ялгарлын талаарх судалгааны тайлан, холбогдох сургалтууд	Загвар төслийг хэрэгжүүлсэн байна.	БХБЯ	ЭХЯ, ЭХЗХ, БОАЖЯ	2017-2019

2.6.2	Барилга, аж үлдвэрийн салбарт эрчим хүчний хэмнэлтийн жишиг төсөл хэрэгжүүлэх	15 аж ахуйн нэгж байгууллагад хийсэн эрчим хүчний хэмнэлтийн аудитын тайлан	15 аж ахуйн нэгж байгууллагад эрчим хүчний хэмнэлтийн аудит хийж, хэмнэлтийн үр дүнг тооцоолсон байна.	ЭХЯ, ЭХЗХ		2017
2.6.3	Эрчим хүчний аж ахуйн нэгж байгууллагад эрчим хүчний аудит хийх	23 аж ахуйн нэгж байгууллагад хийсэн эрчим хүчний хэмнэлтийн аудитын тайлан, дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч хэмнэлт	23 аж ахуйн нэгж байгууллагад эрчим хүчний хэмнэлтийн аудит хийж, хэмнэлтийн үр дүнг тооцоолж, дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч хэмнэгдэж дамжуулалт, түгээлтийн алдагдал буурсан байна.	ЭХЯ, ЭХЗХ		2017-2018
2.6.4	Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх	Хэмнэлтийн менежер, эрчим хүчний аудитор	Эрчим хүчний хэмнэлтийн 110 менежер, эрчим хүчний 50 аудитор бэлтгэсэн байна.	ЭХЯ, ЭХЗХ		2017-2018
2.6.5	Ногоон барилгын шаардлагад нийцүүлэн барилгын норм, стандартыг шинэчлэх, норм стандартад хий дамжуулах систем төлөвлөх шаардлагыг тусгах	Барилгын дулаан хамгааллын норм, стандарт	Барилгын дулаан хамгааллын норм, стандартыг шинээр болон шинэчилэн боловсруулж, мөрдүүлсэн байна.	БХБЯ, СХЗГ		2017-2018
2.6.6	Монгол гэрийн дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр стандартыг шинэчилж мөрдүүлэх	Монгол гэрийн стандарт	Гэрийн стандартыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлсэн байна.	СХЗГ	БХБЯ	2017-2025
<b>Үйл ажиллагааны чиглэл 7.</b> Хот, суурин газрын дулааны хангамж, шугам сүлжээг өргөтгөх, шинээр дулааны эх үүсвэр барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, нүүрсний хэрэглээ, хаягдлыг бууруулахад чиглэсэн технологийн шинэчлэл хийх						
2.7.1	Аймгийн төвүүдийн дулааны шугам сүлжээг шинэчлэх	10-аас доошгүй аймгийн төвийн төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн систем, дулааны станц	Сүхбаатар аймгийн төвийн дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгуудад байгаль орчинд ээлтэй, үр ашиг өндөртэй дулааны станц, дулааны шугам сүлжээ барьж, ашиглалтанд оруулсан байна.	ЭХЯ	АЗДТГ, ХХ	2017-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 8.</b> Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор шинэчлэх						

2.8.1	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх	Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх шинэчлэгдсэн байгууламж	Хаягдал бохир усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, Туул голын усны бохирдол буурсан байна.	БХБЯ, НЗДТГ, ҮХГ	БОАЖЯ	2017-2020
2.8.2	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид лагийг бүрэн боловсруулах, дахин ашиглах технологи нэвтрүүлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэх	Лаг боловсруулах судалгаа, зураг төсөл	Лаг боловсруулах судалгаа хийж, зураг төслийг боловсруулсан байна.	БХБЯ, НЗДТГ		2017
		Төв цэвэрлэх байгууламжийн лагийг бүрэн боловсруулах, дахин ашиглах технологи	Төв цэвэрлэх байгууламжийн лагийг бүрэн боловсруулж, дахин ашиглах технологийг нэвтрүүлсэн байна.	БХБЯ, НЗДТГ		2018-2021
2.8.3	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний насжилтыг уртасгах, шинэчлэх, засварлах ажилд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний засвар, шинэчлэлт	Улаанбаатар хотын цэвэр, бохир усны 48 км шугам сүлжээнд доторлогоо хийгдэж, шинэ технологи нэвтрүүлсэн байна.	БХБЯ, НЗДТГ		2017-2021
2.8.4	Дархан хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих	Дархан хотын цэвэрлэх байгууламж	АХБ-ны зээлээр Дархан хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчилж, ашиглалтанд оруулсан байна.	БХБЯ, аймгийн ЗДТГ		2017-2020
2.8.5	Дорноговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих	Дорноговь аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламж	Аймгийн төвд шинээр бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, цэвэрлэсэн усыг дахин ашиглах, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.	БХБЯ, аймгийн ЗДТГ		2017-2019
2.8.6	Өмнөговь аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих	Өмнөговь аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламж	Аймгийн төвд шинээр цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, цэвэрлэсэн усыг дахин ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.	БХБЯ, аймгийн ЗДТГ		2017-2020
<b>Үйл ажиллагааны чиглэл 9.</b> Гэр хорооллын айл өрхийн үнс, хог хаягдлыг хадгалах зориулалтын цэг болон хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх машин механизмын тоог нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хог хаягдлыг ашиглах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих						
2.9.1	Гэр хорооллын айл өрхийн үнс, хатуу хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх дэд бүтцийн байгууламж, машин механизмыг хүртээмжтэй болгох	1-2 дэд төвд байгуулсан дундын хог хаягдлыг хүлээн авах байгууламж	Хог хаягдал хүлээн авч ангилан ялгаж, шахаж пресслэх бага оврын дундын байгууламжийг хотын дэд төвүүдэд байгуулсан байна.	НЗДТГ	БОАЖЯ	2018-2020

2.9.2	Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх дулааны цахилгаан станц барих	Хог хаягдлыг дахин боловсруулж эрчим хүч үйлдвэрлэх 32МВт-ын дулааны цахилгаан станц	Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх 32 МВт-ын дулааны цахилгаан станц барьсан байна.	ЭХЯ	ҮХГ, НЗДТГ	2018-2022
<b>Үйл ажиллагааны чиглэл 10.</b> Аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалттай байгууламж байгуулж, аюултай хог хаягдал хяналтгүй тархах байдлыг хумих						
2.10.1	Аюултай хог хаягдлын түр хадгалах, устгах зориулалтын байгууламж байгуулах	Аюултай хог хаягдлын ландфиллын зураг төсөл	Аюултай хог хаягдлын ландфиллын зураг төсөл боловсруулсан байна.	БОАЖЯ	БХБЯ, НЗДТГ	2017
		Аюултай хог хаягдлыг байгальд сөрөг нөлөө багатай аргаар булшилж устгах байгууламж	Аюултай хог хаягдлыг байгальд сөрөг нөлөө багатай аргаар булшилж устгах байгууламжийг барьж ашиглалтад оруулсан байна.	БОАЖЯ, НЗДТГ	БХБЯ	2018-2021
2.10.2	Аюултай хог хаягдлын тооллого хийх	Улсын хэмжээнд хийсэн аюултай хог хаягдлын тооллогын нэгдсэн дүн, мэдээлэл	Аюултай хог хаягдлын эх үүсвэр, үүсэлтийн нэгдсэн мэдээлэл бий болсон байна.	БОАЖЯ	Бүх яамд, АНЗД	2017
2.10.3	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр боловсруулж устгах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн салбарын бүх шатанд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	Нийслэлд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал, устгалын төв байгууламжийг шинэчлэн засварлаж, хэвийн ажиллагааг хангасан байна.	ЭМЯ	СЯ, БОАЖЯ, НЗДТГ, НЭМГ	2017-2025
			Орон нутагт эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал, устгалын байгууламжийг барих, ашиглалтанд оруулж, хэвийн ажиллагааг хангасан байна.	ЭМЯ	СЯ, БОАЖЯ, АЗДТГ, АЭМГ	2017-2025
<b>Үйл ажиллагааны чиглэл 11.</b> Ашиглалтаас гарсан сав, баглаа боодол, зай хураагуур, аккумулятор, өдрийн гэрлийн шил, элэгдсэн дугуй, ажилласан тос зэрэг хог хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч нь хариуцаж эргүүлэн татах зохицуулалт болон тэдгээр хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тохиолдолд олгох урамшууллын тогтолцоог бий болгох						
2.11.1	Үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч нь хог хаягдлыг хариуцаж эргүүлэн татдаг зохицуулалтыг судлан хэрэгжүүлэх	Судалгааны тайлан, зохицуулалт	Бүтээгдэхүүний импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгчдэд шаардлага тавьж, хаягдлыг эргүүлэн татах, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бий болгосон байна.	ХХААХҮЯ, БОАЖЯ	ГЕГ, холбогдох яамд	2017-2019

2.11.2	Дахин боловсруулах, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хүлээн авах цэгүүдэд тавих шаардлагыг сайжруулах	Дахин боловсруулах, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хадгалах, ангилах, устгах, тээвэрлэхтэй холбоотой шаардлага, стандарт	Хаягдлыг хадгалах, ангилах, устгах, тээвэрлэхтэй холбоотой шаардлага, стандартыг боловсруулж мөрдүүлсэн байна.	ХХААХҮЯ	СХЗҮГ, НЗДТГ, БОАЖЯ	2017-2019
2.11.3	Аккумулятор, ажилласан тос, дугуй зэрэг хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийн технологийг сайжруулахад дэмжлэг үзүүлж бохирдлыг бууруулах	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд хийсэн технологийн шинэчлэл, технологийн үнэлгээ	Хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийн технологи сайжирч, тэдгээрээс гарах бохирдлыг бууруулсан байна.	ХХААХҮЯ	холбогдох яамд	2017-2021
2.11.4	Нийлэг уутны импорт, хэрэглээг хязгаарлах, хаягдал гялгар уут дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжих	Дотоодын үйлдвэрлэл болон хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр	Импортын нийлэг уут, улавч зэргийн гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэгчид хөнгөлттэй зээл олгохыг бодлогоор дэмжиж, хаягдлыг дахин боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээг хангасан байна.	ХХААХҮЯ, СЯ	ГЕГ, холбогдох яамд	2017-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 12.</b> Нүүрсний давхаргын метан хийн нөөцийн судалгааг эрчимжүүлж, нүүрс баяжуулах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах үйл ажиллагааг дэмжих						
2.12.1	Метан хийг ашиглах боломжит нөөцийг тогтоох судалгааг эрчимжүүлэх	Хайгуул судалгааны ажил	Нүүрсний давхаргын метан хийн хуримтлалын эрэл, хайгуулын судалгааны ажлыг эрчимжүүлж, метан хийн нөөцийг тогтооход бодлогын дэмжлэг үзүүлэн, холбогдох санал санаачилгыг дэмжин, хамтарч ажилласан байна.	УУХҮЯ	ЭХЯ, ААНБ	2017-2021
2.12.2	“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлэх	“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ болон Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ /БОННБҮ/-г хийж	ТЭЗҮ болон БОННБҮ хийгдсэн байна	УУХҮЯ	ЭХЯ БХБЯ НЗДТГ	2017-2018



		батлуулах				
		Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсан байна.	УУХҮЯ, ҮХГ	ЭХЯ БХБЯ НЗДТГ	2017-2025
<b>Үйл ажиллагааны чиглэл 13.</b> Хот, суурин газрын нутаг дэвсгэрт түүхий нүүрс хэрэглэхийг зогсоох бодлогын хүрээнд зорчигч суудлын галт тэргийг цахилгаан халаалтад үе шаттай шилжүүлэх						
2.13.1	Хот суурин газрын нутаг дэвсгэрт зорчигчийн вагоны халаалтыг цахилгаан халаалтад үе шаттайгаар шилжүүлж, түүхий нүүрсний хэрэглээг халах	Өндөр хүчдэлийн 6 МВт-ын дэд станц	Өндөр хүчдэлийн 6 МВт-ын дэд станц баригдаж, зорчигчийн 159 вагоныг цахилгаан халаалтын системээр тоноглох нөхцлийг бүрдүүлсэн байна.	ЗТХЯ	ЭХЯ, НЗДТГ УБТЗ ХНН	2017-2022
		Цахилгаан халаалтын системээр тоноглогдсон зорчигчийн вагон	Зорчигчийн 87 вагоныг цахилгаан халаалтын системээр тоноглож, нийт 159 вагон цахилгаанаар халдаг болсон байна.	ЗТХЯ	ЭХЯ, НЗДТГ УБТЗ ХНН	2018-2023
		Зорчигчийн вагоны галлагаанд нэвтрүүлсэн сайжруулсан шахмал түлш	Зорчигчийн вагоны халаалтад түүхий нүүрсийг орлуулах сайжруулсан түлш хэрэглэх туршилт, судалгаа хийж, нэвтрүүлсэн байна.	ЗТХЯ	ЭХЯ, БОАЖЯ УБТЗ ХНН, ХХ	2018-2021 2017-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 14.</b> Үйлдвэрлэл, үйлчилгээнээс үүссэн орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах, байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашиглахад чиглэсэн стандартуудыг шинэчлэн тогтоож мөрдүүлэх						
2.14.1	ЗГ-ын 2005 оны 127-р тогтоолоор батлагдсан тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад нэмэлт оруулж мөрдүүлэх	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт	Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад нэмэлт оруулсан байна.	СХЗГ, МХЕГ	БОАЖЯ	2017-2018
2.14.2	Амины орон сууц, дэлгүүр, бөөний худалдааны төв, үйлчилгээний барилга, ШТС, машин угаалгын газар, авто засвар зэрэгт орчны бохирдлын бууруулахад чиглэсэн стандарт тогтоож мөрдүүлэх	Шинэ болон шинэчлэгдсэн стандартууд	Нийтийн ариун цэврийн байгууламж, хог хаягдлын зохистой менежмент зэрэг орчны бохирдлын бууруулахад чиглэсэн стандарт тогтоож, мөрдүүлсэн байна.	СХЗГ, МХЕГ	БОАЖЯ Холбогдох яамд	2017-2019

2.14.3	Орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах, байгальд ээлтэй дэвшилтэд техник, технологи, стандартын чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтууд, сургалтын материал, гарын авлага	Жилд 500-аас доошгүй хүнийг сургалтад хамруулсан байна.	БОАЖЯ, СХЗГ	Холбогдох яамд	2017-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 15.</b> Агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийг бууруулах инновацийн судалгаа, технологийн хөгжлийг дэмжин санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон улсын сангуудаас санхүүгийн дэмжлэг авахад дэмжлэг үзүүлэх						
2.15.1	Аж үйлдвэрийн салбарт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл хэрэгжүүлэх	Эрчим хүчний удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх эрчим хүчний хэмнэлт, үр ашиг бүхий жишиг үйлдвэр	Эрчим хүчний удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх эрчим хүчний хэмнэлт, үр ашиг бүхий жишиг үйлдвэрийг байгуулсан байна.	ЭХЗХ	ЭХЯ, БОАЖЯ	2017-2018
2.15.2	Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдоогүй алслагдсан төрийн байгууллагын дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүч болон бусад үр ашигтай технологи ашиглан шийдэх	53 хорооны барилгын дулаан хангамжийг шийдвэрлэсэн төсөл	53 хорооны барилгын дулааны хэрэглээг сэргээгдэх эрчим хүч болон бусад үр ашигтай технологи ашиглан шийдвэрлэсэн байна.	НЗДТГ		2017-2021
